



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 422

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.“МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай:

1.1.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 01/4647 дугаар албан бичиг, Авлигатай тэмцэх газрын 2021 оны 05/10526 тоот албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг харгалзан Батбаярын Мөнхтамирыг “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлаар томилж, контрактыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу байгуулах.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ